



ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ
ᠭᠣᠪᠢ-ᠠᠯᠲᠠᠢ ᠠᠶᠢᠮᠦᠭᠢᠨ
ᠵᠠᠰᠠᠭ ᠳᠠᠷᠭᠢᠨ
ᠵᠠᠬᠢᠷᠠᠮᠵᠢ

МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 03 сарын 03 өдөр

Дугаар А/110

Алтай хот

“Нээлттэй Алтай” арга хэмжээг зохион
байгуулахад хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын 2021 оны 106 дугаар тогтоолоор баталсан “Шинэ сэргэлтийн бодлого”-ын 4.2, 4.3 дахь заалт, аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн тэргүүлэх чиглэл “Сумдын шинэчлэл-Хөдөөгийн хөгжил” төсөл хөтөлбөр, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 73 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын Удирдлагын зөвлөлийн 2023 оны 10 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.“Алсын хараа-2050” урт хугацааны хөгжлийн бодлого, “Шинэ сэргэлтийн бодлого”-ыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд дэвшүүлсэн хот, хөдөөгийн сэргэлтийн зорилтыг хангах, Улаанбаатар хот болон төв суурин газраас Говь-Алтай аймагт шилжин ирж суурьших иргэдийн ажиллаж, амьдрах нөхцөл боломжийг нэмэгдүүлэх, орон нутагт үйл ажиллагаа явуулах аж ахуйн нэгжийг дэмжих цогц арга хэмжээний хүрээнд “Нээлттэй Алтай” арга хэмжээг Улаанбаатар хотод 2023 оны 03 дугаар сарын 03-ны өдөр зохион байгуулж, “Бүжиг дэглээч Баярбаатар төв” ТББ-аар гүйцэтгүүлсүгэй.

2.Шаардагдах 17,494,000 (арван долоон сая дөрвөн зуун ерэн дөрвөн мянга) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг Засаг даргын Тамгын газар (Ш.Эрдэнэбат)-т даалгасугай.

3.Үйл ажиллагааны нарийвчилсан төлөвлөгөөг баталж, ажлыг хуваарилан чанартай зохион байгуулж, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг ажлын хэсэг (Г.Чинбат)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

О.АМГАЛАНБААТАР

